



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 30

Мөрөн сум

Даваацэрэнгийн Ган-Эрдэнийг бие даан
нэр дэвшигчээр бүртгэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 32 дугаар зүйлийн 32.2, 32.3, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 38 дугаар зүйлийн 38.2, 38.2.2, 40 дүгээр зүйлийн 40.2.5, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн сонгуулийн хорооноос ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигчээр дахин бүртгүүлэхээр баримт бичиг ирүүлсэн Даваацэрэнгийн Ган-Эрдэнийн баримт бичиг бүрэн, хуульд заасан шаардлагыг хангасан тул Даваацэрэнгийн Ган-Эрдэнийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигчээр бүртгэсүгэй.

2. Захиргааны актын хувийн хэрэг бүрдүүлж, тогтоолыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойргоос бие даан нэр дэвшигчээр бүртгүүлэхээр баримт бичиг ирүүлсэн (Д.Ган-Эрдэнэ)-д 2020 оны 09 дүгээр сарын 20-ны дотор мэдэгдэх буюу баталгаат шуудангаар хүргүүлэхийг аймгийн сонгуулийн хорооны нарийн бичгийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх журам, заавар, Улсын онцгой комисс, мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 21 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигч (Д.Ган-Эрдэнэ)-д зөвлөсүгэй.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн сонгуулийн хорооны 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 дугаар тогтоолын эрх зүйн үйлчлэлийг 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг мэдэгдсэн буюу гардан авснаас хойш 7 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Х.ГАН-ОЧИР

Р.МАШБАТ